

# ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД НӨЛӨӨЛЖ БУЙ НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ГАЗАРЗҮЙН ХҮЧИН ЗҮЙЛ

Б.Батбуян<sup>1</sup>, Б.Нацагсүрэн<sup>1</sup>

<sup>1</sup>ШУА, Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Нийгэм эдийн засгийн газарзүйн салбар

Э-шуудан: [naya.naagii9@gmail.com](mailto:naya.naagii9@gmail.com)

## SOCIO-ECONOMIC AND GEOGRAPHICAL FACTORS AFFECTING THE MIGRATION

B. Batbuyan, B. Natsagsuren

### Abstract

This paper is targeted to identify socio-economic and geographical factors affecting the migration and to explain this migration causes by the theory of pull-push factors. Total of 7 soums are involved in the research. 211 herder households and households from the centre of the soums were selected by random sampling and analysed. Market, social services, infrastructure and unemployment rate are the main factors affecting the migration. These factors are becoming pull factors to some of the soums and push factors to the others. Population are migrating greatly in soums with high unemployment rate and are migrating to the soums located near to large cities or soums that is highly developed mining industry and infrastructure in order to increase the employment rate or their income. Population migration is relatively low on soums with low rate of unemployment and has well developed infrastructure.

**Түлхүүр үгс:** Шилжих хөдөлгөөн, татах хүчин зүйл, түлхэх хүчин зүйл

### Оршил

Шилжих хөдөлгөөн нь хүн амын өсөлт өөрчлөлтөд нөлөөлдөг гурван гол хүчин зүйлийн нэг учраас нийгэм эдийн засгийн газарзүйн судалгаанд шилжих хөдөлгөөнийг тусгайлан авч судалдаг. Хүн амын шилжих хөдөлгөөнийг тодорхойлох нь улс орны хөдөлмөрийн нөөцийг тодорхойлох, хот хөдөөгийн хүн амын тооны харьцааг зөв тогтвортой байлгах, хот суурин, үйлдвэрлэлийн төвүүдийг байгуулах, засаг захиргааны хуваарийг боловсронгуй болгох, үйлдвэрлэл, аж ахуйг ажиллах хүчээр хангах [10], ажиллах хүчний нөөцийг хуваарилах зэрэг нийгэм эдийн засгийн ач холбогдолтой. Монгол орны хувьд хот хөдөөгийн хооронд шилжих, нэг аймгаас нөгөө аймагт шилжин суух хөдөлгөөн, нэг сумаас нөгөө суманд, ихэвчлэн томоохон хот суурин газарт хүн ам төвлөрснөөр энэхүү үйл явц нь хүн амын нутагшилтыг өөрчлөх хүчин зүйл [1] болж байна. Хүн амын шилжих хөдөлгөөний энэхүү урсгалын гол чиглэл, хэлбэр нь хөдөөгөөс суурин иргэншлийн хэв шинжид татагдаж хүн ам хот суурин руу шилжиж [2] байна. Иймээс хүн амын шилжих хөдөлгөөнд нөлөөлж буй нийгэм эдийн засгийн газарзүйн хүчин зүйлийг тодорхойлох нь ихээхэн чухал болоод байна.

Энэхүү өгүүллийн гол зорилго нь шилжих хөдөлгөөнд нөлөөлж буй нийгэм эдийн засгийн газарзүйн шалтгааныг Татах-Түлхэх хүчин зүйлийн онолоор тайлбарлахад оршино.

Дэвшүүлж буй судалгааны чиглэл:

- Хот суурин газрын зах зээлийг бараадан шилжин суурьших малчин өрхийн тоо нэмэгдэж байна.

### Судалгааны аргазүй

Судалгаанд байгалийн бүс бүслүүр, аймгийн төвөөс алслагдсан байдлыг харгалзан аймгийн төвөөс 0-40 км-ын зайн шатлалд орших Булган аймгийн Орхон, Өмнөговь аймгийн Ханхонгор, аймгийн төвөөс 81-119 км-н зайн шатлалд орших Өмнөговь аймгийн Цогтцэций, Булган аймгийн Хангал, 120-оос дээш км-ын зайн шатлалд орших Булган аймгийн Баяннуур, Дундговь аймгийн Өндөршил, Цагаандэлгэр сумдыг сонгон авав.

Шилжих хөдөлгөөнд оролцож буй шалтгааныг татах хүчин зүйл, түлхэх хүчин зүйлээр тайлбарладаг бөгөөд үүнийг хээрийн судалгааны асуулгын аргаар тодорхойлох нь [3] илүү үр дүнтэй. Иймээс сонгож авсан 7 сумдаас санамсаргүй түүврийн аргаар 141 малчин өрх, 70 сумын төвийн өрхөөс асуулга судалгаа авч, Excel программд асуулт тус бүрийн хариултыг кодолж оруулан үр дүнг боловсруулав. Судалгаанд хамрагдсан

сумдын хоорондын зай, татах радиусыг  $p = \sqrt{\frac{s}{n}}p = \sqrt{\frac{s}{n}}, L = \frac{\sqrt{\frac{s}{n}}\sqrt{\frac{s}{n}}}{2}$  томъёо ашиглан [5] гаргасан болно.

### Онол

Газарзүйн харилцан адилгүй нөхцөл, эдийн засгийн хөгжлийн өөр, өөр түвшин, нийгмийн харилцан адилгүй халамж, үйлчилгээ зэрэг нь шилжигчдийн хувьд таатай, “чанартай” орчин руу тэмүүлэх сэдлийг бий болгодог гэж үзээд ийм шалтгаанаар хүн амын шилжих хөдөлгөөнийг тайлбарладаг Татах-Түлхэх онолын хандлага байна. Энэ онолын үзэл баримтлал нь хувь хүн ажил эрхлэх боломж сайтай, эдийн засгийн идэвхтэй бүсэд ойртож амьдралын нөхцөл байдлаа сайжруулах зэрэг эдийн засгийн газарзүйн хүчин зүйл, шаардлагаар шилжих хөдөлгөөн явагддаг [4] гэж үздэгт оршино. Хоцрогдсон хөдөө нутгаас шинжлэх ухаан, соёл, үйлдвэрлэлийн төв болох хот суурин руу тэмүүлсэн шилжих хөдөлгөөний зүй тогтлыг тайлбарласан хэрэг бөгөөд хөгжиж байгаа орнуудын хүн амын шилжих хөдөлгөөнийг авч үзэхэд илүү тохиромжтой байдаг. Татах-Түлхэх гэдэг нь шилжих хөдөлгөөнийг (шилжин ирэгч, явагч) бий болгож буй хүчин зүйлийг ялган тайлбарласан хэрэг юм.


### Судалгааны үр дүн

**Шилжих хөдөлгөөний урсгал:** Судалгаанд хамрагдсан өрхүүдээс шилжин ирсэн өрхийг хаанаас (аль аймаг сумаас) тухайн цэгт ирснийг тодруулах зорилгоор социологийн судалгааг хийв.

Хүн амын шилжих хөдөлгөөнд хот суурины тоо, хэмжээ эдийн засгийн хүчин чадал их байх тутам хот суурины шилжигчдийг татах хүрээ, далайц төчнөөн их болдог. Хот суурины татах хүчийг ерөнхийд нь хоорондын зайгаар гаргаж болох бөгөөд зай нь хэчнээн бага бол шилжилтийн эрчим төчнөөн их байдаг [5].

Судалгаанд хамрагдсан сумдын шилжих хөдөлгөөний чиглэлийг шилжиж ирсэн өрхийн хаанаас ирснээр харуулсан болно (1 дүгээр зураг). Судалгаанд хамрагдсан өрхүүдэд сум хоорондын шилжилт хөдөлгөөн давамгайлж байна. Хангайн бүсийн төлөөлөл болсон Булган аймгийн Баяннуур, Орхон, Хангал сумдад Баян-Өлгий аймгийн

Ногооннуур, Увс аймгийн Бөхмөрөн, Улаангом, Түргэн, Завхан аймгийн Баянхайрхан, Сантмаргац, Тэс, Хөвсгөл аймгийн Рашаант, Ренчинлхүмбэ, Цагаан-Уул, Архангай аймгийн Жаргалант, Цэцэрлэг, Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Сэлэнгэ аймгийн Хушаат, Булган аймгийн Дашинчилэн, Тэшиг, Рашаант, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр зэрэг сумдаас шилжиж ирсэн өрхүүд байна. Харин Говийн бүсийн төлөөлөл болсон Дундговь аймгийн Өндөршил, Цагаандэлгэр, Өмнөговь аймгийн Ханхонгор, Цогтцэций сумдад Дундговь аймгийн Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Хулд, Эрдэнэдалай, Өмнөговь аймгийн Даланзадгад, Мандал-Овоо, Манлай, Дорнод, Дорноговь аймгуудаас шилжин суурьшжээ. Судалгаанд хамрагдсан сумдаас харахад Хангайн бүсийн төлөөлөл болсон сумдад баруун, төвийн бүсийн аймгуудын сумдаас шилжиж ирсэн өрхүүд дийлэнх хувийг эзэлж байна. Говийн бүсийн төлөөлөл болсон сумдад тухайн аймгийн өөр сумаас шилжиж ирсэн өрхүүд байна.



1 дүгээр зураг. Шилжих хөдөлгөөний чиглэл  
Эх сурвалж: Хээрийн судалгаа НЭЗГ-2014

**Шилжих хөдөлгөөнд нөлөөлж буй хүчин зүйлс:** Зах зээлд ойртох шалтгаанаар Хангал сум хамгийн өндөр 38.9 хувь, ажил эрхлэх шалтгаанаар Баяннуур, Цагаандэлгэр, Цогтцэций сумд хамгийн өндөр 33.3 хувь, нийгмийн үйлчилгээ хүртэх шалтгаанаар Хангал сум хамгийн өндөр 30.8 хувь, дэд бүтэц бараадах шалтгаанаар Баяннуур сум хамгийн өндөр 66.7 хувь, бэлчээр нутаг бараадах шалтгаанаар Баяннуур сум хамгийн өндөр 36.4 хувь, хамаатан саднаа бараадах шалтгаанаар Баяннуур, Орхон сумд хамгийн өндөр 27.3 хувьтай байна.

Судалгаанд хамрагдсан өрхүүдээс ямар шалтгааны улмаас уугуул нутгаасаа

нүүх болсон талаар асуулга явуулахад өрх бүр хэд хэдэн төрлийн үндсэн шалтгааныг тоочжээ. Уугуул нутгаасаа нүүх болсон шалтгаануудыг ач холбогдолтой гэж үзсэнээр жагсаахад:

- Хамаатан саднаа бараадах
- Зах зээл бараадах
- Нийгмийн халамж үйлчилгээ авах
- Бэлчээр нутаг бараадах
- Ажил эрхлэх
- Дэд бүтэц бараадах

Хамаатан садантайгаа ойр амьдарч, бие биеэ дэмжин тэтгэх, тусламж авах зорилгоор ирсэн гэсэн хариулт нь нийт хариултын 30.1 хувийг эзэлж байна. Удаах байрыг мал аж ахуйн бүтээгдэхүүн борлуулах, ахуйн хэрэгцээний бараа бүтээгдэхүүнийг хямд үнээр авах гэж зах зээлд ойртсон гэсэн хариулт 24.7 хувийг эзэлж байгаа юм. Мөн үр хүүхдэдээ илүү сайн боловсрол олгох, эмнэлгийн үйлчилгээ хүртэх, нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдах гэсэн хариулт 17.8 хувийг эзэлж байна.

#### 1 дүгээр хүснэгт. Шилжих хөдөлгөөнд оролцож буй шалтгаан

Сум	Зах зээлд ойртох		Ажил эрхлэх		Нийгмийн үйлчилгээ авах		Дэд бүтэц		Бэлчээр нутаг бараадах		Хамаатан саднаа бараадах	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Баяннуур	2	11.1	2	33.3	3	23.1	2	66.7	4	36.4	6	27.3
Орхон	4	22.2	0	0	3	23.1	0	0	2	18.2	6	27.3
Хангал	7	38.9	0	0	4	30.7	1	33.3	1	9.1	3	13.6
Өндөршил	0	0	0	0	0	0	0	0	1	9.1	1	4.5
Цагаандэлгэр	1	5.6	2	33.3	2	15.4	0	0	0	0	3	13.6
Ханхонгор	4	22.2	0	0	1	7.7	0	0	3	27.3	1	4.5
Цогтцэций	0	0	2	33.3	0	0	0	0	0	0	2	9.1
Бүгд	18	100	6	100	13	100	3	100	11	100	21	100

Эх сурвалж. Хээрийн судалгаа НЭЗГ-2014

Бэлчээр нутаг бараадан малаа дагаж, мал аж ахуй болон бусад өрхийн аж ахуй эрхлэх гэсэн хариулт 15.1 хувь, орлогын эх үүсвэр хайн (хувийн бизнес эрхлэх), ажил олж хийх (Орон нутагт ажлын байр байхгүй) гэсэн хариулт 8.2 хувь, томоохон хот суурин руу явахад ойр, зам дагуу оршдог, үүрэн телефоны сүлжээ сонголттой, эрчим хүчний баталгаат эх үүсвэртэй зэрэг дэд бүтэц бараадан ирсэн гэсэн хариулт 4.1 хувийг эзэлж байна. Эдгээр шалтгаанууд нь тухайн сумын татах хүчин зүйл болж байна.

Байгалийн бүс бүслүүрээр үзэхэд говийн бүсэд орших Дундговь аймгийн Өндөршил, Цагаандэлгэр, Өмнөговь аймгийн Ханхонгор, Цогтцэций сумдын гол татах хүчин зүйл нь бэлчээр нутаг, ажлын байр болж байна. Харин хангайн бүсэд орших Баяннуур, Орхон, Хангал сумдын гол татах хүчин зүйл нь зах зээл, боловсрол, нийгмийн халамж үйлчилгээ зэрэг шалтгаанууд байна.

Аймгийн төвтэй ойрхон орших сумдын гол татах хүчин зүйл нь зах зээл байна. Харин аймгийн төвөөс хол орших сумдын гол татах хүчин зүйл нь бэлчээр бараадан малаа даган нүүж байна.

2 дугаар хүснэгт. Сум орон нутагт тулгамдаж буй асуудал

Сум	Зах зээл		Хөдөлмөр эрхлэлт		Нийгмийн үйлчилгээ		Дэд бүтэц		Байгаль		Бусад	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Баяннуур	11	16.9	19	14.2	5	9.8	4	6.3	19	17.8	2	9.5
Орхон	10	15.4	15	11.2	9	17.6	5	7.9	11	10.3	3	14.3
Хангал	10	15.4	25	18.7	8	15.7	5	7.9	7	6.5	1	4.8
Өндөршил	7	10.8	13	9.7	6	11.8	13	20.6	27	25.2	2	9.5
Цагаандэлгэр	6	9.2	29	21.6	6	11.8	12	19.0	6	5.6	4	19.1
Ханхонгор	19	29.2	25	18.7	4	7.8	13	20.6	12	11.2	3	14.3
Цогтцэций	2	3.1	8	6.0	13	25.5	11	17.5	25	23.4	6	28.6

Эх сурвалж: Хээрийн судалгаа НЭЗГ-2014

Судалгаанд хамрагдсан сумдад тулгамдаж байгаа асуудлыг илрүүлэхийн тулд нийт асуулгад хамрагдсан өрхөөс танай суманд тулгамдаж байгаа ямар асуудал байна вэ гэсэн асуултад Ханхонгор, Баяннуур, Орхон, Хангал сумдад мал аж ахуйн бүтээгдэхүүнийг зарж борлуулахад хүндрэлтэй байдаг, Цагаандэлгэр, Ханхонгор, Хангал сумдад ажлын байр хомс шилжилт хөдөлгөөн ихтэй, Орхон, Хангал суманд сургууль, цэцэрлэг, эмнэлэг хангалтгүй, Цогтцэций суманд гэмт хэрэг ихтэй, Өндөршил, Цагаандэлгэр, Ханхонгор суманд барилга байгууламж хуучирсан, аймгийн төв болон бусад суурин газруудад хүрэх зам тээврийн боломж муутай гэж хариулсан бол Цогтцэций, Өндөршил сумдад үржил шимтэй газрын хомсдол (бэлчээр, хадлан, газар тариалан), экологийн асуудлууд (усны хомсдол, уур амьсгалын өөрчлөлт) ихтэй байна гэж хариулжээ. Тухайн сум орон нутагт тулгамдаж байгаа асуудлууд шилжих хөдөлгөөнд нөлөөлж улмаар шилжих хөдөлгөөнд **түлхэх хүчин зүйл** болж болох юм.

#### Хэлэлцүүлэг

Суурин руу ойртох тусам сумын нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувийн жин болон нэг хүнд ногдох малын тоо өсөж байна [9]. Үүнээс үүдэн бид хот суурин газрын зах зээлийг бараадан шилжин суурьших малчин өрхийн тоо нэмэгдэж байна гэсэн таамаг дэвшүүлсэн бөгөөд судалгааны үр дүнгээр бидний таамаг батлагдаж байна. Зэх зээл бараадахаас гадна малчид хамаатан саднаа бараадах, нийгмийн үйлчилгээнд ойртох, ажлын байр хайх зэрэг шалтгаанаар шилжих хөдөлгөөнд их орж байна. Тухайн сум орон нутгийн шилжих хөдөлгөөнд нөлөөлж буй түлхэх хүчин зүйлийг төр засаг болон сум орон удирдлагууд анхаарч ажиллавал малчдыг сумандаа тогтоон барихаас гадна тухайн суманд малчдыг татах хүчин зүйл болж болох юм.

#### Дүгнэлт

Шилжилт хөдөлгөөний гол татах хүчин зүйл нь зах зээл, боловсрол, бэлчээр, ажлын байр болж байгааг дээрх судалгаа харуулж байна. Эдгээр хүчин зүйлс нь байгалийн бүс бүслүүр аймгийн төвөөс алслагдсан зай, хатуу хучилттай зам дайрсан дайраагүй зэрэг гаднын хүчин зүйлсээс шалтгаалан өөр өөр байна. Тухайлбал: Өндөршил, Цагаандэлгэр, Ханхонгор, Цогтцэций суманд эсгий ноосны үйлдвэр, тоосго,

блокны үйлдвэрүүд нь ажлын байрыг бий болгож хүмүүсийг татах гол хүчин зүйл болж байна. Харин Хангайн бүсэд бэлчээр нутаг малчдыг татах гол хүчин зүйл болж байна. Аймгийн төвтэй ойрхон орших Орхон, Хангал сумдад зах зээл, боловсрол гол татах хүчин зүйл болж байна.

Хангал, Ханхонгор, Цагаандэлгэр, сумдад ажилгүйдэл, Баяннуур, Ханхонгор сумдад мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг зарж борлуулахад хүндрэлтэй, Орхон, Өндөршил, Цогтцэций сумдад бэлчээрийн доройтол, Өндөршил, Цагаандэлгэр сумдад зам тээвэр, Орхон, Хангал сумдад нийгмийн үйлчилгээ их тулгамдаж байгаа асуудал болж байна. Эдгээр тулгамдаж байгаа асуудлууд нь шилжих хөдөлгөөний түлхэх хүчин зүйл болж болох юм.

Тухайн судалгааны ажил нь шилжих хөдөлгөөний татах-түлхэх хүчин зүйлийн онолыг ашигласан бөгөөд цаашид өөр онолуудыг ашиглан дэлгэрүүлэн судлах шаардлагатай байна.

### **Талархал**

Энэхүү судалгааны ажил нь нийгэм эдийн засгийн газарзүйн салбарын 2014-2016 онд хэрэгжүүлсэн “Хүн амын нутагшилт, суурьшлын орон зайн зүй тогтол” сэдэвт ажлын хүрээнд хийгдсэн 2014 оны судалгааны үр дүн бөгөөд уг судалгааг амжилттай хийж гүйцэтгэхэд бүхий л нөхцөл бололцоог хангаж, дэмжиж тусалж ажилласан сэдвийн удирдагч Б.Батбуян болон салбарын хамт олондоо талархал илэрхийлье.

### **Ашигласан ном, хэвлэл**

- [1] Баянтөр М., Гунгаадаш Б., Нямбуу Ч., Сүхбаатар О., 1971. “БНМАУ-ын хүн амын газарзүйн зарим асуудлууд”, Улаанбаатар.
- [2] Болормаа Ц., 2011. “Эмзэг байдлаас тогтвортой хөгжил рүү: байгаль орчин, хүний хөгжил”, Монгол Улсын хүний хөгжлийн илтгэл, Улаанбаатар.
- [3] Доржготов Д., 2013. “Монгол орны төв бүсийн нийгэм-эдийн засаг, физик газарзүйн иж бүрэн тодорхойлолт, мэдээллийн сан” 2011-2013 оны сэдэвт ажлын тайлан, ШУА, Газарзүйн Хүрээлэн, Улаанбаатар.
- [4] Оюунгэрэл Ж., 2004. “Нийгэм-эдийн засгийн шинэ нөхцөл дэх монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний газарзүйн асуудлууд” Улаанбаатар.
- [5] Сүхбаатар О., 1973. “БНМАУ-ын хүн амын шилжих хөдөлгөөн”, Улаанбаатар.
- [6] Үндэсний статистикийн хороо., 2014, “Булган, Өмнөговь аймгийн статистикийн товчоон” Улаанбаатар.
- [7] Үндэсний статистикийн хороо., 2000. “Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл-2000”, Улаанбаатар.
- [8] Үндэсний статистикийн хороо, 2013. “Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл-2013”, Улаанбаатар.
- [9] Хишигдорж Д., 2014. “Хот орчмын бүс дэх жижиг суурин газрын үүргийн бүтэц”, Улаанбаатар.
- [10] Шийрэв-Адьяа С., 2000. “Нүүдэлч малчдыг суурьшуулах газарзүйн зарим асуудал”, Улаанбаатар.